

Сонирхогч этгээдүүдэд

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зарласан ЗТХЯ/20210101127 дугаартай Шинэ тойрог авто зам төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар) тендер шалгаруулалтад сонирхогч этгээдүүдээс ирүүлсэн тодруулгад захиалагчаас өгсөн хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	Тендерийн хугацааг бага байгаа тул та бүхэн 2 долоо хоногоор сунгаж өгөх боломж байна уу? Тендерт шаардлагатай апостиль авах, материалуудын орчуулга гэхээр хугацаа шаардлагатай байгаа тул 2 долоо хоногоор 2024 оны 11-р сарын 28 хүртэл сунгаж өгнө уу	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3. дахь хэсэг Нээлттэй тендер шалгаруулалтын тендер хүлээн авах эцсийн хугацаа ажлын 15-аас дээш, энэ хуулийн 8.3-т заасан тендер шалгаруулалтад ажлын 20-иос дээш өдөр байхаар заасны дагуу зарласан.
2	Бид Оросын Холбооны Улсаас ЗТХЯ/20240101127/01/01 тоот урилгын дугаартай "Шинэ тойрог авто зам" төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/ тендер шалгаруулалтанд оролцож байгаа бөгөөд манай улсын банкнуудад Монгол улсын арилжааны банк руу SWIFT ашиглан бидний гаргуулж байгаа тендерийн баталгааг илгээх боломжгүй тул, Бид банкинд гаргуулсан тендерийн баталгаагаа Төрийн худалдан авах ажиллагааны газраар дамжуулан цахим системээр ирүүлж болох уу? Энэхүү тендерт гаргуулж буй тендерийн баталгааг хүлээн авч цахим системд байршуулах тухай Төрийн худалдан авах ажиллагааны газарт мэдээлж өгнө уу.	Гадаадын этгээд гадаад улсын банкнаас баталгаа гаргуулах тохиолдолд Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 дугаар тушаалын хавсралт "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-ын 4 дэх хэсгийн дагуу гаргаж ирүүлнэ. Монгол улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллага нь журмын 4.3.2-т заасныг хэрэгжүүлэхэд техникийн шийдлээс шалтгаалан цахим системд гадаадын банканд байршуулсан баталгааг дамжуулах боломжгүй тохиолдолд уг баталгааны хувийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлснийг үндэслэн цахим системд бүртгэх боломжтой.
3	ЗТХЯ/20240101127/01/01 тоот урилгын дугаартай "Шинэ тойрог авто зам" төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/ тендер	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3. дахь хэсэг Нээлттэй тендер шалгаруулалтын тендер хүлээн авах эцсийн хугацаа ажлын 15-аас

	шалгаруулалтын материал илгээх хугацаа багатай материал бэлдэх, тендерийн баталгаа гаргуулж байршуулахад хүрэлцэхгүй байгаа тул 30 хоногоор сунгаж 2024 оны 12 сарын 14 хүртэл хойшлуулж өгнө үү.	дээш, энэ хуулийн 8.3-т заасан тендер шалгаруулалтад ажлын 20-иос дээш өдөр байхаар заасны дагуу зарласан.
4	Тендерийн баримт бичиг ба ажлын даалгаварыг англи хэл дээр байршуулж өгнө үү	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.дахь хэсэгт заасны дагуу цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.